



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 26 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл,
хөтөлбөрүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 6.3.4, 6.3.6, 6.3.8, 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2, 23.1.3, 23.1.4, 23.1.5, 23.1.8, 23.1.10, 23.1.11, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.17 дахь заалт, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.30, 2.1.2.12, 2.1.2.8, 2.1.3.8, 2.1.3.14, 2.1.3.15 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дагалдан ажиллаж хөдөлмөрт шилжих нь” туршилтын хөтөлбөрийн 3.1.1, 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-д заасан ажил олоход хүндрэлтэй иргэн. Тус бүлэг нь нийт хөтөлбөрт хамрагдагч иргэдийн 60 хүртэлх хувийг эзэлнэ.”

“3.1.3. Залуучууд (20 хүртэлх хувь).”

2. Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Job center” төвийг дэмжих туршилтын төслийг батлах тухай Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулга бүхий заалтыг нэмсүгэй:

“6.10. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга туршилтын төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.”

“7.2. Шинээр байгуулагдах “Job center” төвийн 1 биржид 15 хүртэлх сая төгрөг, нэг “Job center” төвд 30 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй 1 удаа олгож болно.”

Дараах заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

“3.1.4, 6.7 дахь заалтын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт гэснийг “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн” гэж, 5.1 дэх хэсгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг гэснийг “2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл” гэж өөрчлөх.

“Job center” төвийг дэмжих туршилтын төслийн 6.10, 7.2, 7.3 дахь заалтыг тус тус хассугай.

3. “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-т доор дурдсан агуулга бүхий заалтыг нэмсүгэй:

“2.3.1. “Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст тухай жилд зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн байгууллагын 30 хүртэл хувьд тухайн орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг үндэслэн хамруулж болно.”

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 онд батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Т.АУБАКИР